

Олон улсын худалдааны бодлого, төлөв байдлын судалгаа хариуцсан шинжээч, Сүхбаатар Нямдорж  
2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| №   | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ  | Шалгуур үзүүлэлт         | Гүйцэтгэлийн түвшин  |   | Хүрсэн түвшин / биелэлт  | Эхэлсэн, дууссан хугаца   | Биел элтийн хувь |
|---|---|--------------------------|--|---|--|---|------------------|
|   |   |                          | Суурь түвшин   | Хүрэх түвшин  |  |   |                  |
| 1   | 2   | 3                        | 4  | 5   | 6  | 7   |                  |
| 1.1. Худалдаа, эдийн засгийн гадаад хамтын ажиллагаа болон гадаад, дотоод худалдааны бодлогыг тодорхойлох, нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар хангах, холбогдох гэрээ, хэлэлцээрийг тохиролцох, байгуулах, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтэд хяналт тавих; |   |                          |  |   |  |   |                  |
| 1   | Хоёр болон олон талт эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлийг тодорхойлж, хамтын ажиллагааны нэгдсэн бодлого боловсруулах, төлөвлөх, зохицуулах, холбогдох гэрээ, хэлэлцээрийг тохиролцох, байгуулах, хамтран ажиллах, хэрэгжилтийн үр ашгийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ авна. | Хэрэгжилтийн явц, хувиар | Хоёр талт эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх хүрээнд нийт 5 санамж бичиг, 2 протокол байгуулсан Нийт 22 хэлэлцээрийн төсөл, 26 ярианы сэдэвт санал боловсруулж, холбогдох чиг үүргийн яамдад хүргүүлсэн. | Тухай бүр шаардлагатай арга хэмжээг авч ажилласан байна. /100 хувь/ | 1. Шивээхүрэн-Сэхээ боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын Монголын талын Шивээхүрэн өртөөний замын доод, дээд бүтэц, ус зайлуулах байгууламж, гадна цахилгаан хангамж, барилга байгууламжийн гэрэлтүүлэг, дохиолол холбооны байгууламж, ачилт буулгалтын чингэлэг терминалын талбайн барилга угсралтын ажлууд бүрэн дууссан. 2. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100%             |

|  |              |          |               |           |                  |   |      |  |
|--|--------------|----------|---------------|-----------|------------------|---|------|--|
|  |              |          |               |           |                  | <p>“Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын гүүрийг хамтран барих, төмөр замын инженерийн нарийвчилсан зураг төслийг боловсруулж, магадлуулах ажил бүрэн дууссан болно.</p> <p>3. Ханги-Мандал боомтын төмөр замын ажил бүрэн хийгдсэн. Хил холболт гэрээ байгуулагдаж ажил хийгдсэнээр Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын эдийн засгийн төмөр замын төв коридорын салаа болох бөгөөд ОХУ-аас БНХАУ руу, БНХАУ-аас ОХУ-руу чиглэсэн ачаа тээврийн дөт зам болох боломж бүрдүүлэхээр ажилласан.</p> |      |  |
| <p>1.2. Импортыг орлох салбарыг дэмжиж, экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, худалдааны тэнцлийг сайжруулахад чиглэсэн бодлого боловсруулах, Монгол Улсын нэгдэн орсон, байгуулсан олон талт болон хоёр талт худалдааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийн үр ашгийг сайжруулах арга хэмжээ авах, шинээр гэрээ хэлцэл байгуулах санал гаргах, боловсруулах, худалдаанд тулгарч буй саад хүндрэлийг багасгаж, хөнгөвчлөх бодлого тодорхойлох, нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар хангаж, худалдааны (экспорт, импорт) санхүүжилтийн үйл ажиллагааны эрхлэх чиг үүргийн хүрээний асуудлаар Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагааг бодлогоор зохицуулах, чиглүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;</p> |              |          |               |           |                  |   |      |  |
| 2  | Эдийн засаг, | Хэрэгжил | Монгол Улс нь | Тухай бүр | 1. Монгол, Японы | 1-р сар, 2-   | 100% |  |

|  |   |   |   |   |   |   |  |
|--|---|---|---|---|---|---|--|
|  | <p>худалдааны чиглэлээр байгуулсан олон талт болон хоёр талт гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг үр ашгийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ авч, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.</p> | <p>тийн явц, хувиар<br/><br/>/100 хувь/</p> | <p>Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн ба Ази номхон далайн худалдааны хэлэлцээр, Ази номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх тухай хэлэлцээр, Европын холбооны хөнгөлөлтийн ерөнхий системд тус тус нэгдэн орсон байх ба Япон улстай Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулсан.</p> | <p>судалгаа хийн дүгнэлт гаргаж, санал боловсруулан, холбогдох арга хэмжээг авч ажилласан байна. 100 хувь</p> | <p>харилцаа, хамтын ажиллагааг “Энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх Тусгай стратегийн түншлэл”-ийн хүрээнд өргөжүүлэн хөгжүүлэхэд анхааран ажиллах талаар санал солилцлоо. Мөн түншлэлийн хүрээнд Япон Улсын Засгийн газраас Монгол Улсад үзүүлэх хөгжлийн албан ёсны тусламжийг эргэн сэргээх хүсэлтэй байгаагаа илэрхийллээ. Түүнчлэн цаашид хөгжлийн санхүүжилтийн хүрээнд ЖАЙКА-гийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудлыг өргөтгөх, хүчин чадлыг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллах боломжийг эрэлхийлж, Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, энэ хүрээнд худалдаа, хөрөнгө оруулалтыг</p> | <p>р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар</p> |  |
|--|---|---|---|---|---|---|--|

|   |   |                          |   |  |   |   |      |
|---|---|--------------------------|---|--|---|---|------|
|   |   |                          |   |  | нэмэгдүүлэх, бизнесийн орчныг сайжруулахад хамтран ажиллах талаар санал солилцлоо.  |   |      |
| 3 | Худалдаанд тулгарч буй саад хүндрэлийг багасгаж, хөнгөвчлөхөд чиглэсэн бодлогыг тодорхойлон, импортыг орлох салбарыг дэмжих, экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, гадаад худалдааны тэнцлийг сайжруулахад чиглэсэн худалдааны бодлогыг тодорхойлж, нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар ханган, хэрэгжилтэд хяналт тавина. | Хэрэгжилтийн явц, хувиар | Экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох, худалдааны тэнцлийг сайжруулахад чиглэсэн бодлого боловсруулж нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар ханган ажилласан. Худалдааг хөнгөвчлөх, уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2023 оны 178 дугаар тогтоолын төслийг боловсруулан хэлэлцүүлж батлуулсан. | Тухай бүр судалгаа хийж, санал боловсруулж, холбогдох арга хэмжээг авч ажилласан байна. /100 хувь/ | 1. Бүгд Найрамдах Азербайжан Улсын Гадаад хэргийн дэд сайд Эльнур Мамедовыг хүлээн авч, уулзалтаар Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцын талуудын 29 дүгээр дээд хэмжээний уулзалтыг амжилттай зохион байгуулсанд баяр хүргэж, Хоёр улсын эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, харилцан ашигтай хөрөнгө оруулалтын механизмыг бий болгох, худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, тэр дундаа хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортыг дэмжих чиглэлээр санал солилцож энэ онд бизнес форумыг Монгол Улсад зохион байгуулахаар тохиролцлоо. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

|   |   |                          |   |   |  |   |      |
|---|---|--------------------------|---|---|--|---|------|
| 4 | Нэгжийн худалдааны (экспорт, импорт) санхүүжилтийн үйл ажиллагааны эрхлэх чиг үүргийн хүрээний асуудлаар Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагааг бодлогоор зохицуулах чиглүүлэх арга хэмжээ авч, хяналт тавина. | Хэрэгжилтийн явц, хувиар | Засгийн газрын 2024 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 92 дугаар тогтоолоор Хөгжлийн банкны үйл ажиллагааг холбогдох хуульд нийцэж байгаа эсэх талаар хяналт шалгалт хийх үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон удирдамжийг баталсан. ЭЗХЯ-ны ТНБД-ын 2024 оны 10 дугаар сарын 4-ны өдрийн Б/22 тушаалаар дэд ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгийн зүгээс холбогдох удирдамжийн дагуу холбогдох хяналт, шалгалтын үйл ажиллагааг явуулж ажилласан. | Тухай бүр шаардлагатай арга хэмжээг авч ажилласан байна. /100 хувь/ | 1. Монгол Улсын хөгжлийн стратегийг дэмжих, санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх, олон улсын хөгжлийн банкны жишигт нийцсэн үйл ажиллагааны стандартыг нэвтрүүлэх зорилгоор Монгол Улсын Хөгжлийн банк бодлогын цогц шинэчлэлээ эхлүүлээд байна. Энэ хүрээнд тус банк өнгөрсөн баасан гарагт (2025.05.16) “Хөгжил ба шинэчлэл” сэдэвт форум зохион байгуулж, хуулийн шинэчилсэн найруулгын төслөө олон нийтэд танилцууллаа. 2. “Эдийн засаг, хөгжлийн яам Хөгжлийн банкны хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн хувьд банкны санхүүгийн чадавхыг дээшлүүлэх болон хууль, эрх зүйн орчныг сайжруулах арга хэмжээний төлөвлөгөөгөө Засгийн газарт танилцуулан ажилласнаар тодорхой | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |
|---|---|--------------------------|---|---|--|---|------|

|  |  |  |  |  |                                   |  |
|--|--|--|--|--|-----------------------------------|--|
|  |  |  |  |  | ахиц дэвшлүүд<br>эхнээсээ гарсан. |  |
|--|--|--|--|--|-----------------------------------|--|

### НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Үүрэг даалгавар | Өгсөн субъект | Биелэлт |
|---|-----------------|---------------|---------|
| 1 | 2               | 3             | 4       |

### ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| №   | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ                                  | Шалгуур үзүүлэлт                      | Гүйцэтгэлийн түвшин                                 |   | Хүрсэн түвшин / биелэлт  | Эхэлсэн, дууссан хугаца   | Биел элтийн хувь |
|---|---|---------------------------------------|---|---|--|---|------------------|
|   |   |                                       | Суурь түвшин  | Хүрэх түвшин  |  |   |                  |
| 1   | 2   | 3                                     | 4   | 5   | 6  | 7   |                  |
| 4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх |   |                                       |   |   |  |   |                  |
| 1   | Хариуцсан чиг үүргийн хүрээнд сургалтад хамрагдсан байна.         | Сургалтад хамрагдах                   | Сургалтад хамрагдсан байна.                         | Сургалтад хамрагдсан байна./100 хувь/                         | Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Тяньжин хотноо 2025оны 05 сарын 21-нээс 06 сарын 03-ны өдрүүдэд Чөлөөт бүсийн бүтээн байгуулалт худалдаа хөрөнгө оруулалт сэдвийн хүрээнд зохион байгуулагдсан сургалтад хамрагдсан | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100%             |
| 2   | Төрийн албаны мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байна. | Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах. | Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байна. | Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байна./100 хувь/ | 1.Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад хамрагдахаар төлөвлөж байна.   | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 50%              |

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:

ТЗУГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Т.Баясгалан /...../

ТАЙЛАН ГАРГАСАН:

Олон улсын худалдааны бодлого, төлөв байдлын судалгаа хариуцсан шинжээч, Сүхбаатар Нямдорж /...../

Огноо: 2025.06.25



*C. Нямдорж*